



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/93

Биндэр сум

**Хагас жилийн мал
тооллого явуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, "Статистикийн тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дэх хэсгийн заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2026 оны А/271 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2026 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны хооронд явуулсугай.

2.2026 оны "Хагас жилийн мал тооллого"-ын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Отгонбаяр	Засаг даргын орлогч
Гишүүд:	Н.Болормаа	Баян-Өндөр багийн Засаг дарга
	Э.Мөнгөншагай	Мандалхаан багийн Засаг дарга
	Ж.Ганзоригт	Баянгол багийн Засаг дарга
	Х.Амарзаяа	Дэлгэрхаан багийн Засаг дарга
	Б.Тунгалаг	Онон багийн Засаг дарга
	Х.Гэлэгжамц	Мал эмнэлийн тасгийн дарга
	Г.Нямдолгор	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	А.Мишээлт	Санхүү албаны даргын үүргийг

түр орлон гүйцэтгэгч

3.Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

4."Хагас жилийн мал тооллого"-ын дүнг эцэслэн боловсруулж, дүн мэдээг 2026 оны 06 дугаар сарын 15-ний дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

